

**ОЛОН НИЙТИЙН ТАТВАРЫН БОЛОВСРОЛЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 06 дугаар сарын 19

	Хийгдэх ажил	Гүйцэтгэл
Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хийх үйл ажиллагаа		
2.1.1.	Татварын боловсрол олгох анхан шатны бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг жил бүр хийж, үр дүнг тооцдог болох;	
2.1.2.	“Олон нийтийн татварын боловсрол” олгох хэлэлцүүлгийг 2 жилд 1 удаа зохион байгуулах;	Аймгийн СТСХ-тэй хамтран баялаг бүтээгч, бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаа татварын эрсдэлээс урьдчиланах сэргийлэх, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг болгох зорилггор “Хариуцлагатай татвар төлөгч -2024” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Сургалт зөвлөгөөнд 15 сумын бизнес эрхлэгчдийн төлөөлөл 250 орчим татвар төлөгч оролцов.
Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд хийх үйл ажиллагаа		
2.2.1.	Татварын төлөгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын материал бэлтгэх;	Татвар төлөгчдөд зориулсан Дундговийн амьдрал сонинд 2 удаагийн нийтлэлээр мэдээ мэдээлэл бэлгэн хэвлүүлж тараасан.
2.2.3	Татвар төлөгчдөд татварын талаарх мэдлэгийг түгээх, тэднийг чадавхижуулах, татварын эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх;	2024 онд шинээр бүртгүүлсэн аж ахуй нэгжийн удирдлагуудад татвар төлөгчийн эрх, үүргийг танилцуулж, татварын хуулийг тайлбарлан таниулж, тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж байх талаар заавар зөвлөмжийг өгч ажилласан. 2024 онд байгуулагдаж буй газрын удирдлага нь ихэвчлэн малчин тул бүртгэл баталгаажуулалтыг татварын газарт ирүүлэн хийлгэж, , тоон гарын үсэг авах хүсэлт болон тайлан илгээх заавар зөвлөмжийг өгч, тайлан ирүүлээгүй тохиолдолд авагдах зөрчлийн хариуцлагыг сайтар танилцуулж өгсөн.
2.2.4	Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд татварын тухай ойлголтыг тоглоом, контентоор дамжуулан хүргэх;	
2.2.5	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт татварын боловсрол олгох агуулгыг оруулах ажлыг эхлүүлэх;	Ерөнхий боловсролын Цэгц билиг сургуулийн ахлах ангийн хөвгүүдийн бүлгэмийн сурагчид, Говийн ирээдүй цогцолбор, Мандал сургуулиудын дунд ангийн сурагчдад Эрдмийн далай цогцолбор сургуулийн бага анги, /нийт 222 сурагчид / 6 удаа "Татвар хөгжлийн үндэс" сэдвээр танхимын сургалт зохион байгууллаа. Мөн Эрдмийн далай цогцолбор сургууль, Говийн-ирээдүй цогцолбор сургуулийн ахлах ангийн сурагчидад

		мэргэжил сонгохтой нь холбогдуулан татварын газрын үйл ажиллагаатай танилцах өдөрлөгийг зохион байгууллаа
2.2.6	Их, дээд сургуулийн оюутнуудын сургалтын хөтөлбөрт татварын боловсрол олгох агуулгыг нэмэгдүүлэх, хичээлийн агуулгаас бусад байдлаар мэдлэгийг дээшлүүлэх;	
2.2.7	Татвар төлөгчдийн боловсролыг цахим хэлбэрээр хүргэх боломжийг нэмэгдүүлэх;	ХХОАТ-ын тайлангийн хөнгөлөлтийн тайлан илгээхтэй холбоотой, мөн төрийн албан хаагч бүрийн ТТ-06 тайланг хуулийн хугацаанд ирүүлэхээр сумдын ИТХ-тай хамтран Бичил, жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчид zoom-ээр, төрийн албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгууллаа.
2.2.8	Татвар төлөгчид мэдээлэл, сургалт, сурталчилгаа, түүний үр дүнг тооцоход мэдээллийн технологийг ашиглах;	Дундговь аймгийн Татварын газар хуудас, dundgovi.gov.mn хаягуудаар 190 мэдээ мэдээллийг 87531 татвар төлөгчдөд хүргэсэн.
2.2.9	Татварын албаны цахим хуудас /www.mta.gov.mn/-ийн мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх;	
2.2.10	Татварын боловсрол олгох боловсон хүчнийг чадавхижуулах;	БТТХТ, ЖТТХТ-ийн дарга нарт үүрэг болгож тушаалын хэрэгжилтийг гаргах төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Авлигын эсрэг 1 удаагийн сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн танилцуулга сургалт, газрын залуучуудын зөвлөлөөс албан хаагч бүр “Мэдлэгээ хуваалцаж” сургалтыг 7 хоног бүрийн лхагва гаригт тогтмол хуваарийн дагуу явуулж байна. Мөн албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэн чадавхижуулах хүрээнд Хүмүүнлэг сургуулийн МХУЗ-ын Отгонсүрэн башгаар монголбичгийн хичээлийг заалган албан хаагч бүр монголбичгээр компьютерт бичиж суралцацгааж байна.
2.2.11	Татварын боловсрол олгоход шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах;	
2.3.	Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд хийх үйл ажиллагаа	
2.3.1	Татвар төлөгчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанд	2024.04.01-06.28 өдрийг хүртэл хугацаанд Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран аймгийн засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан татварын

	/сургалт, сурталчилгаа/ орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;	ерөнхий хууль, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон татварын бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж илэрсэн зөрчлийг арилган хариуцлага тооцож, татвар төлөгчдөд заавар зөвлөгөө өгч ажиллах төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллаж байна. -Төвийн татварын улсын байцаагчид 3 багт хуваагдан зах худалдааны төвд үйл ажиллагаа явуулж буй иргэдийн цахим төлбөрийн баримт олголт, татвар төлөлтөнд хяналт тавьж ажиллалаа. - Баянжаргалан, Сайхан-Овоо, Өндөршил, Цагаандэлгэр сумдад ажиллаж иргэдэд ибаримт олголт, татварын хуулийн талаар сургалт мэдээллийг хүргэж ажиллалаа
2.3.2	Их, дээд сургуулиудын оюутнуудыг татварын талаар мэдлэг олгох сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах чиглэлээр дэмжиж ажиллах;	
2.3.3	Татварын боловсролын сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгтэй хамтран үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч нарт “Татвар төлөгчийг татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг ТМЗ, ММНБ, Гавъяат эдийн засагч Я. Батжаргал багш хийлээ. Мөн хувийн хэвшлээс Хаанбанк, Төрийнбанкны салбарын захирлууд оролцон бизнес эрхлэгч татвар төлөгч нарт төлбөрийн баримт олголтыг банкны пос ашиглан гаргаж болох болон , цахимаар татвар төлөх зэрэг мэдээллийг хүргэн хамтарч ажилласан.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАР